

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нямын Дашцэрэн	Дугаар	L012
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Улаанбаатар хот	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Чойнхорлин аймагт Идгаа дацан	Сүм хийдийн дугаар	UBR 912
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	UB 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Улаанбаатар хотын Идгаа дацан

Хүрээнд Намдоллин, Маяа, Номчийн, Сангайн, Дугарын, Чойнхорлин, Мэргэн хамбын, Бизъяагийн, ноёны, Эрхэм тойны, Эх дагинын, Вангайн гээд 30 аймаг байсан. Би 6,7 настайдаа лам болсон. Чойнхорлин аймагт аймаглаж байсан. 1938 онд хар болсон. 1984 онд тэтгэвэрт гарсан. Манай аав лам байсан. Манай Чойнхорлин аймаг Шалш гэдэг сахиустай. Би аймагтаа 2 жил аймаглаад 9 настайдаа дацанд орж, 9 жил болсон. Хадаг, шидүв, жумбарай юлжин, дондонжу, ог, гом, гавдамба дом. 9 наснаасаа 17 хүртлээ сурч дом хийсэн. 30 аймгийн хамгийн дээд тал нь 1000 ламын данстай. Доод тал нь 350 ламтай байсан. 1000-т, 500-т, 300-т гэсэн схемтэй байсан. Манай аймаг бол 300-т аймаг. 30 аймгаас 1000-т аймаг цөөхөн. 500-т олон.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Идгааг 1911 онд сүүлд байгуулагдсан. Манайд 2000-аад лам байсан болов уу. Жанрайсагтай нэг жил Богд байгуулсан юм. Наадуул нь хамаагүй эртнийх. 5-р Богдоос эхэлж байгуулсан. 5, 6, 7, 8 гээд 8-р Богд манай дацанг байгуулсан юм.

Товхон гэж байсан юм. Ухаан нь тэр аймгийн тэр сум тийм аймагт хурна. гэсэн. Товхон гэж хуваарь л юм даа. Баруун хүрээ, Эрдэнэ Зуу бол Цэцэн тойныд. Миний ижий тэр нутгийн хүн. Манай аав Сүхбаатар аймгийн хүн. Тэгээд би аавыгаа дагаад Чойнхорлинд хурсан юм. Ижий болон эмээ ээж, ах нарыгаа дагавал Цэцэн тойны аймагт хурах ёстой байсан.

Дацанд хурахад хуваарь байхгүй. Тэр хүний багш ах лам нь аль дацангийн хүн бэ гэдгээс хамаарна. Хоёрдугаарт игчаанаас хамаарна. Чойрын ном гурван үндэстэй. Зүүн дацан Гүнчэн ламын, Хойд дацан Сэражавзанба ламын игчаатай, Баруун дацан Банчэн ламын игчаатай байсан. Хойд дацан яагаад тийм цөөхөн болов гэхээр Богд авчирсан. Тэрнээс өмнө Сэра игчааны ном байхгүй байсан юм.

Раднаа шунлайв гэж хүн байсан. Олон шавь нартай. Сүүлд баригдаад гарч ирсэн. Би шавь нь байсан. Гомбожав хамба гээд олон нэртэй ламтай байсан. Олон гэвш нар байсан. Гэлэн сахилтай лам цөөхөн байсан байх. Дацанд хамба цорж гэж байдаггүй. Хамгийн толгойлогч нь шунлайв гэж байсан. Тэгээд хоёр унзад, хоёр гэсгүйтэй. Зүүн Хүрээнд долоон цорж байсан. Ёндон хамба 1-р цорж нь байлаа.

Идгаа дацангийн шунлайв нь Раднаа шунлайв гэж байсан. Намайг ороход. Нэлээн удаж олон жил шунлайв хийсэн хүн байсан. Унзад гэсгүй нар ч олон хүн байсан.

Идгаа өдөр бүр шаржин гэж хурна. Тэгээд л номоо үзнэ. Жилдээ нэг сахиус хурна. Зуны тэргүүн сарын 15-нд хурал хурна. Тогтмол хурал цөөхөн. Гурван дацан тогтмол хурал цөөхөн. Жандаг гарвал яахав дээ оройн ерөөл энэ тэр хурна. Гавж болно. Сар бүр л 3, 4 хүн болно. Хоол унд, цав манж барина. Номоо хэлэлцэнэ. Гурван дамжаа байдаг. Эхлээд домын дамжаа тэгээд гавжийн дамжаа сүүлд нь аграмбын дамжаа. Аграмба нар цөөхөн. Жүдэд болдог. Эхлээд уншлагаа үзнэ. Тэгээд чойрын номоо үзэж байгаад домын дамжаа барьчихна. Домын дамжаа бариад чойрынхоо 5 боть номыг үргэлжлүүлэн үзэж байгаад гавж болно. Домын дамжаа барьснаас хойш 10 гаруй жил болоод гавж болно. Гавж болчихоод агийнхаа номыг үзнэ. Дүйнхорт. Агийнхаа номыг үзэж гүйцээд аграмба болно. Дом хийчихээд гавж болж чадахгүй гэвэл сулаар тарна. Тэгээд яахав өөрийн мэргэжлээр тэр хүн эмээ барина уу, гүрмээ хийнэ үү, хар болно уу өөрөө мэднэ. Хийд дээрээ ирвэл хурна. Сулаар тарсан гаарамба гэж нэрлэнэ. Гавж болоход эхлээд хөрөнгө, тэгээд ном харна. Ихээ хөрөнгөтэй баян хүн бол ном муутайдаа бас гавж болно. Ер тэгээд дээр үеийн чинь гэвш нар ядуу байсан юм шүү дээ. Ном сайтай. Хөрөнгө муутай. Тэгээд ном сайн үзээд явбал заяандаа бурханы ачаар болчихно. Хөдөөний нэг ах дүү нь, шавь нь гавж болгож өгдөг байсан юм. Бас бадар барьж байсан юм. Хөдөө явна. Айл хэсээд би нэг гавж болох санаатай та бүгдээс бадар гуйж явна гэнэ. Ер нь бадар их барьж байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гавж нь 3 хоног дамжаа барина. Лам нар өмнө нь очиж ном хаяна. Хэлэлцэнэ. Шунлайв нь хараад сууж байсан.

Цагаан сарын дамжаа, зургаан сарын дамжаа байсан. Зун хайлангийн үеэр дамжаа байхгүй. Өвөл суларна гэж 45 хоног байдаг тэр үед дамжаа барихгүй. Бусад үед нь сар бүр гавжийн дамжаа барина. Хайланг Идгаад хийдэг байсан. Хайлан гэдэг чинь дэг журам тогтоох тухай юм. Номгүйдээ хамаагүй. Хөдөөнөөс ч анчин байсан хүн ч ирж сууна. Сахил аваад. Хайлангийн үеэр цагаан хоол иднэ. Архи уухгүй, морь ч унахгүй, бусдыг зовоохгүй гэж. Гэлэн хүнийг хүндэтгэдэг. Жинхэнэ гэлэн бурханы явж байсан замаар явдаг. Хайланд хоёр гурван зуугаад хүн суудаг байсан.

Хадаг, шидүв, жумбарай юлжин, дондонжу, ог, гом, гавдамба гэд нэг нэг жил сураад явна. Номтой номгүй хамаагүй. Овоо нэг нь ном үзнэ. Ном үзэхгүй нь дом тавиад л яваад өгнө.

Дацангуудад хурал хурдаггүй. Цогчэнд л ихэвчлэн хурна. Тэнд Хангал хурна, сор зална. Гүрмийнх гэж тусгай дуган байсан. Зүүн хүрээнд Пионерийн ордны тэнд байсан юм. Гандангийн том лам нар чинь гүрэм мүрэм хийхгүй. Хороогоор явахгүй. Хороогоор чинь явахад пайз өгч явуулдаг байсан юм. Лам хүнийг хороогоор хонуулахгүй. Гандангийн 4 хаалганд 4 цагдаа байсан юм. Ганданд эмэгтэй хүн оруулахгүй.

1937 оны зун Гандангийн хуралд хурж байсан бүх хүүхдүүдийг хар болгосон. Би тэгэхэд эмээгийндээ хөдөө байсан. Тэрэнд ороогүй юм. 1937 оны намар ирэхэд бүх хүүхэд хар болсон байсан. Би тэгээд л хар болсон. Дээрээс нь том улсыг нь барьчихсан. За тэгээд хурал хурах саналтай хүн байсан уу гэсэн. Байна гэсэн. Хэн унзад, хэн гэсгүй, хэн лам нь болох юм гэсэн. Би унзад больё, би гэсгүй нь больё гээд сайн дураараа хурлаа үргэлжлүүлэн явуулж байсан юм. Тэгээд сүүлдээ хавчигдаад ирэхээр нь больсон. Түлхүүрээ Шашны хэрэг эрхлэх газар гэсэн яам байсан юм. Тэнд өгсөн. Улсын болсон. Хөрөнгийг нь аваад, ном судрыг нь шатаагаад, модоор нь үйлдвэр барьсан. Модны артелиг дандаа дуган сүмийн модоор барьсан. 1944 онд би Хорины дарга байсан. Тэгээд банкинд ажиллаж байсан. Тийм учраас лам гэдгээ мэдэгдэж болохгүй байсан. Мэдэгдвэл ажлаас гаргана. Алба ажил өгөхгүй. 1967, 1968 оноос хойш Гандангаар ордог болсон юм. Тагнуул их байсан. Лам байсныг мэдчих вий гэхээс ухаан алдчихна. Тийм л байсан юм. 1984 онд тэтгэвэртээ гарсан. 1989 оноос ардчилал гарч хүмүүс лам болоод Дамбжавын өргөдөлд нэрээ оруулаад орсон. Завсар нь Идгаагийн шунлайв хоёр жил хийсэн. Хар болсон хүнд шагнал өгч байсан. Гандангаар орох юмсан гэж боддоггүй. Аймгийн лам нар аймагтаа хурлаа хурахаас гадна эвтэй аймаг гэж байна. Хадаг мадаг бариад ах дүүгийн найрамдал байгуулж байгаа юм. Эвтэй аймагтаа хурж болно. Мөн хоёр дацанд хурж болно. Хөдөө ямар ч эрдэмтэй ба гавж ба энд ирээд хадгаар орно. Өндөр гэгээний долоон хийдийн нэгэнд л гавж болоогүй бол Хүрээнд гавжаар суухгүй. Эрдэнэзуу, Хэрлэнгийн зүүн хүрээ, Дамбадаржаа, Баруун хүрээ, Амарбаясгалан эд нар орно.